



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019.09.06 № 05/7186
танай _____-ны № _____-т

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ДЭД ДАРГА
Б.ЗАЯАБАЛ ТАНАА

[Handwritten signature]

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийн тухай

Тус газраас Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн Татварын ерөнхий газрын харьяа Нийслэлийн татварын газрын Татварын хяналт шалгалтын хэлтсийн даргаар томилогдохоор нэр дэвшсэн Баатархуягийн Золтуяагийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянаж 2019 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 05/6484 дүгээр албан бичгээр хариуг хүргүүлсэн.

Нэр дэвшигч Б.Золтуяа нь дээрх албан бичигт дурдсан нөхцөл байдлын хүрээнд Нийслэлийн Прокурорын газарт бичгээр хүсэлт гаргасан байх бөгөөд тус прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч, хууль цаазын шадар зөвлөх Ц.Насанбатын 2019 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 4/1604 дүгээр албан бичигт “Нийслэлийн прокурорын газрын хяналтанд байгаа хэргийн цахим бүртгэлээс шалгаж үзэхэд Б.Золтуяад эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан прокурорын шийдвэр гараагүй” талаар дурдсан байна.

Татварын ерөнхий газрын харьяа Нийслэлийн татварын газрын Татварын хяналт шалгалтын хэлтсийн даргын албан тушаалд Баатархуягийн Золтуяаг томилоход Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсэгт дурдсан нөхцөл байдал үүсээгүй байх тул түүнийг тухайн албан тушаалд томилох эсэх асуудлыг өөрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх нь зүйтэй болно.

Хувийг, Б.Золтуяад утас 99116378

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



[Handwritten signature]
Х.ХАШБААТАР

[Handwritten signature]
[Handwritten signature]